




Ард даатгал ХК-ийн 2023 оны

Жилийн тайлан



30
ЖИЛ АРД

ДААТГАЛ
SINCE 1994



АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн танилцуулга

Түүхэн товчоон

Онцлох үйл явдлууд

Даатгалын үйл ажиллагаа

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Ердийн даатгалын салбарын өнөөгийн байдал

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц болон хувьцааны арилжааны мэдээ

Хувьцааны арилжааны мэдээ

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Компанийн засаглал

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа

Хүний нөөц

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Төлөөлөн удирдах зөвлөл

Эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага

Давхар даатгал

Нөхөн төлбөр



АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гүйцэтгэх захиралын мэндчилгээ

Ард Даатгал ХК нь энэ жил үүсгэн байгуулагдаж хөгжсөний 30 жилийн түүхэн ойгоо угтаж буйн баярын мэндийг нийт хувьцаа эзэмшигч, даатгуулагч, хамтран ажиллагч байгууллагууд, үе үеийн нийт ажилтан албан хаагчдадаа өргөн дэвшүүлье!

Энэхүү хөгжлийн 30 жилийн хугацаанд олон зүйлээр анхдагч бөгөөд тэргүүлэгч байж ирлээ. Анхны даатгалын компаниудын нэгдэл, анхны хувьцаат компани, олон олон шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг анхлан нэвтрүүлсээр харилцагчдынхаа санхүүгийн хүндрэлийг хамтдаа амжилттай давж иржээ. Өдгөө харилцагч, хувьцаа эзэмшигчдийн тоо болон компанийн хөрөнгө, эрсдэл хүлээх чадвар, олгож буй нөхөн төлбөрийн дүн, үйлчилгээний нэр хүнд чанараар тэргүүлэгч даатгалын компани болон тогтлоо.

Цаашид цахим үйлчилгээгээр тэргүүлэгч, түргэн шуурхай даатгалын үйлчилгээг үзүүлэгч, бүс нутагтаа үлгэр жишээ компани болох зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Түүхийн дараагийн хуудсыг бүтээлцэхээр бидэнд итгэн хамтран ажилладаг иргэд, түншүүддээ талархал илэрхийлье!

Гэрэлтэй сайхан ирээдүйг хамтдаа бүтээе!



Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал
Г.Цогбадрах

Компаний танилцуулга

Ард Даатгал компанийн хувьд Монгол улсын компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд заасан шаардлагуудыг ханган Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) - ноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаагаа явуулж буй (Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар - 2/16) хувьцаат компани юм.

Түүхэн замнал

Ард Даатгал ХК үүсгэн байгуулагдав	Их Британийн Omni Whittington Group хөрөнгө оруулав	Inernational Quality Era Award (Switzerland, Geneva) шагнал гардав	Оюу толгой төслийн бүтээн байгуулалтанд оролцож эхлэв.	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хэрэгжүүлж эхлэв	МҮХАҮТ-ын Оны Шилдэг Даатгалын компаниар 3 жил дараалан шалгарав.			
1994	2000	2004	2008	2010	2011	2012	2013	2014
Анхны хувийн даатгалын компани болов.	Монгол улсын ТОП-5 даатгалын компанийн нэг болов.	СЗХ-ны ОНЫ ШИЛДЭГ даатгалын компаниар шалгарав.	Агаарын хөлгийн даатгалын үйлчилгээ нэвтрүүлэв	Гранд даатгал ХХК-г өөртөө нэгтгэв.	"Гранд Экспо"-ийн оны шилдэг даатгалын компани болов.	Монгол Улсын Татварын Ерөнхий Газрын дээд шагнал Хөх дэвтэр шагнал гардав.		
Ард Санхүүгийн Нэгдэл ХК хөрөнгө оруулагч болов.	Малын Индексжүүлсэн Даатгалын үйлчилгээг үзүүлж эхлэв.	MSH International Олон Улсын эрүүл мэндийн даатгалыг хэрэгжүүлж эхлэв.	IPO гаргаж нээлттэй хувьцаат компани болов.	Ард Апп-д даатгалын цэс нэмэгдэж, аппаар даатгал хийж эхлэв.	Ковид-19 цар тахлын хамгаалалт бүхий шинэ даатгалын бүтээгдэхүүн боловсруулж зах зээлд нэвтрүүлэв.	Даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулав	Гадаадад зорчигчдын даатгалын хамгаалалтад Ковидын эрсдэлийн хамгаалалтыг багтаалаа	Даатгалын үндсэн системийн шинэчлэл хийгдэв.
2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Давхар даатгалын ТРИТИ гэрээг ХБНГУ-ын давхар даатгагч Ханновер Ре-тэй байгуулав.	Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал ХХК-тай хамтран Тариалангийн даатгал хэрэгжүүлж эхлэв.	АрдКойн урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.	Хөрөнгийн биржийн ТОП-20 индекст 3 жил дараалан багтав.	Хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэж, 10,151 болов.	Харилцагчийг ангилан, мэдээллийн бааз үүсгэх CRM системийг хэрэгжүүлж эхлэв.	Албан журмын даатгалын борлуулалтаар салбартаа тэргүүлэгч болов		

АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Онцлох үйл явдлууд

- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хувьд Монгол Улсын тэргүүлэгч даатгагч болж энэ ажлын хүрээнд 2023 онд **139 мянга** гаруй даатгалын гэрээ байгуулж Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.
- Манай улсын эдийн засгийн гол тулгуур болсон уул уурхайн салбарын мянга мянган ажилтан, тэдгээрийн гэр бүлийг эрүүл мэндийн даатгалд хамруулж, амжилттай хамтран ажиллаж байна.
- MSH China эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөллүүд Ард Даатгал компанид зочилж, мөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй томоохон эмнэлгүүдийн үйл ажиллагаатай танилцан, цаашид үйлчилгээгээ өргөжүүлэн хамтын ажиллагаагаа сайжруулах талаар талууд хамтран хэлэлцээр хийж тохиролцлоо.
- Мөн 2023 оны зун Улаанбаатар хотод үерийн эрсдэлийн улмаас учирсан хөрөнгийн даатгалын хохиролд компанийн зүгээс давхар даагчтай хамтран **1.0 тэрбум** орчим төгрөгийн нөхөн төлбөрийн хохирлыг барагдуулсан.
- Цахим даатгал хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Үндэсний Дата төв, E-Mongolia, Авто Тээврийн Үндэсний Төвтэй хамтран ажиллаж төрийн байгууллагын үйлчилгээгээр дамжуулж даатгалын үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлээд байна.
- Дотоод үйл ажиллагааны хүрээнд үндсэн системийн цогц шинэчлэлтийг хийн хэрэглээнд нэвтрүүлж, хөгжүүлэлтийг тасралтгүй хийж байгаа бөгөөд **70 хүртэл хувийн** автоматжуулалтыг нэвтрүүлсэн нь шинэ ололттой ажил байсан төдийгүй компанийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтад чухал ач холбогдолтой ажил боллоо.
- Жолоочийн хариуцлага, тээврийн хэрэгсэл, эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөрийн хүсэлтийг Ард Апп ашиглан хүлээн авч шийдвэрлэж байна.
- Нийт хөрөнгө **44.2 тэрбум төгрөгт** хүрч, **24 хувь өссөн** нь хувьцаа эзэмшигчдэд таатай үйл явдал боллоо.

Даатгалын үйлчилгээ

Ард Даатгал нь ердийн даатгалын компани бөгөөд албан журмын даатгалаас гадна сайн дурын 50 гаруй төрлийн даатгалын үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Бид Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхны даатгалын нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд жолоочийн даатгал, малын индексжүүлсэн даатгал, газар тариалангийн даатгалыг анхлан хэрэгжүүлэгчдийн нэг билээ.



Тоон үзүүлэлт

#1 Хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй компани	30 Үйл ажиллагаа явуулсан жил	50 гаруй бүтээгдэхүүн үйлчилгээ	10k Хувьцаа эзэмшигч	100 орчим ажилтан	21 Салбар
8.3 Зах зээлд эзлэх хувь (нийт хураамж)	32 тэрбум Хураамжийн орлого	14 тэрбум Олгосон нөхөн төлбөр	243k Даатгуулагчийн тоо	4 Хамтран ажилладаг банк	70 гаруй Хамтран ажилладаг даатгалын зуучлагч

АРД ДААТГАЛ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Даатгалын үйлчилгээ

Ард Даатгал компани нь өнгөрсөн хугацаанд Монгол улсын өнцөг булан бүрд хүрч ажиллаж чадсан бөгөөд 2023 оны байдлаар нийтдээ 243 гаруй мянган даатгуулагчийг даатгалд хамруулаад байгаа төдийгүй үүнээс 4,000 гаруй байгууллагатай 39,000 гаруй гэрээ байгуулж улс орны баялаг бүтээж байгаа бүхий л салбарыг хамруулан даатгалын үйл ажиллагаагаа хүргэн ажиллаж байгаад компанийн хамт олон бахархаж байдаг юм.

 Дэд бүтэц, зам тээвэр, иргэний нисэх, агаарын тээвэр	 Барилга угсралт	 Үл хөдлөх хөрөнгө
 Эрчим хүч, уул уурхай, газрын тос	 Хөдөө аж ахуй	 Худалдаа үйлчилгээ
 Хөнгөн ба хүнд үйлдвэрлэл	 Батлан хамгаалах, цэрэг цагдаа, онцгой байдал	 Банк санхүү, даатгал
 Аялал жуулчлал, спорт	 Эрүүл мэнд	 Мэдээлэл технологи, харилцаа холбоо
 Төрийн ба төрийн бус, олон нийтийн байгууллагууд	 Эрдэм шинжилгээ, боловсрол, хууль эрх зүй	 Олон улсын байгууллага, Элчин сайдын яамдууд

Эрүүл мэндийн даатгал

Бид дотооддоо Ард-Мэнд, олон улсын хэмжээнд Ard-Medicare (Ard-Med) эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг санал болгон 150 мянга гаруй харилцагчдад эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалтай холбоотой даатгалын үйлчилгээ үзүүлж, харилцагчдын тоо өсөн нэмэгдлээ.

ArdMedicare олон улсын эрүүл мэндийн даатгал нь дэлхийн 200 гаруй оронд 330 мянга гаруй гэрээт эмнэлгүүдээр үйлчлүүлэх өргөн сүлжээ бүхий олон улсын MSH China эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллаж, хэрэгжүүлдэг бүтээгдэхүүн юм. MSH China нь даатгалын компани, даатгуулагч-үйлчлүүлэгч, эмнэлгийн байгууллагыг холбож өгөх гүүр болдог.

Манай харилцагчдын хувьд олон улсын эрүүл мэндийн даатгалын шууд төлбөрийн (direct billing) үйлчилгээг Азийн улсууд болох БНХАУ, Солонгос, Япон, Тайланд, Монгол болон Австрали, Герман, Швед, Швейцар зэрэг дэлхийн улс орнууд дахь сүлжээ эмнэлгүүдээр үйлчлүүлж авсан байна.

Эрүүл мэндийн даатгалын алба нь мэргэжлийн чадварлаг эмч нар, даатгалын мэргэшсэн менежерүүдээр багаа бүрдүүлэн ажиллаж байгаа ба иргэдийн эрүүл мэндийн даатгалын боловсролд илүү анхаарч ажиллаж байна. Түүнчлэн эрүүл мэндийн даатгалын ач холбогдол, ирээдүйд учирч болзошгүй эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээлэл, сургалтуудыг мэргэжлийн эмч нартай хамтран 2023 онд 100 орчим байгууллагад 4,500 гаруй хүнийг хамарсан сургалтыг уул уурхайн болон бусад ажлын байранд нь зохион байгуулсан байна.



ЕРДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

15 ердийн даатгалын компани

2 урт хугацааны даатгалын компани

1 дотоодын давхар даатгалын компани

68 даатгалын зуучлалын компани

37 даатгалын хохирол үнэлэгч компани

2,375
даатгалын төлөөлөгч

Даатгалын зах зээл 2023 онд (ердийн даатгал) (сая төгрөг)


	Зах зээл	Зах зээлийн дундаж	Ард даатгал
Даатгалын хураамжийн нийт орлого	388,861	25,924	▲ 32,438
Давхар даатгалын хураамжийн зардал	141,546	8,496	▼ 5,660
Даатгалын хураамжийн цэвэр орлого	236,913	12,098	▲ 25,950
Нийт нөхөн төлбөрийн зардал	118,805	7,476	▲ 14,095
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	96,701	5,215	▲ 8,340
Үйл ажиллагааны зардал	128,454	8,564	▲ 11,252
Нийт хөрөнгийн дүн	469,035	31,269	▲ 44,156
Нөөц сангийн дүн	59,356	3,957	▲ 4,551
Эздийн өмчийн дүн	182,308	12,154	▲ 18,130
Хохирлын харьцаа	56%	-	41%
Зардлын харьцаа	60%	-	56%
Хосолсон харьцаа	116%	-	97%

Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө тайлант хугацаанд 469.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 70.8 тэрбум төгрөгөөр буюу 17.7 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого, түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм.

Хувьцаа эзэмшигчдийн тоон мэдээлэл

2023 оны жилийн эцсийн байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 9,763 хүрч оны эхнээс 248 хувьцаа эзэмшигчээр нэмэгдсэн байна. Тайлант жилд хувьцаа эзэмшигчдийн бүтцэд гарсан томоохон өөрчлөлт байхгүй байна.

Хувьцааны арилжааны хувьд 2023 онд 1.9 сая ширхэг хувьцаа, нийт 1.6 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн бөгөөд дээд үнэ 950 төгрөг, доод үнэ 681 төгрөг хүрсэн бол жилийн арилжааны сүүлийн өдөр 874.5 төгрөгөөр хаагдсан байна. Ингэснээр 2023 он жилийн эцсийн байдлаар компанийн үнэлгээ 21.9 тэрбум төгрөг болсон байна.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БОЛОН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

Бид 1994 онд анхны хувийн даатгалын компани болон байгуулагдаж байсан бөгөөд 2018 онд олон нийтэд нээлттэйгээр хувьцаагаа санал болгон даатгалын салбарт анх IPO хийж Монголын Хөрөнгийн Биржийн 1-р ангиллын хувьцаанд багтан хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болсон байна.

Ард Даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл нь ерөнхий удирдлагаар ханган ажилладаг. Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилон ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчид	2022.12.31		2023.12.31		Өөрчлөлт
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
1 Ард Санхүүгийн Нэгдэл ХК	11,342,832	45.4	11,377,911	45.4	35,079
2 Ардын Тэтгэврийн Данс ХХК	1,445,289	5.8	1,419,393	5.3	(25,896)
3 С.Оргил	1,164,822	4.7	1,164,822	4.7	-
4 Г.Бат-Эрдэнэ	1,164,822	4.7	1,164,822	4.7	-
5 Н.Мөнхнасан	1,140,742	4.6	1,140,742	4.6	-
6 Энержи Интернэйшнл Капитал ХХК	820,750	3.3	866,965	3.3	654,371
7 БиДиСек ҮЦК	599,216	2.4	820,750	0	-
8 Ард Кредит ББСБ ХК	437,006	1.7	441,883	1.5	27,801
9 Ард Бит ХХК	414,082	1.7	437,946	1.7	940
10 Алекс Капитал ҮЦК	358,524	1.4	342,534	0	-
11 Үндэсний Хувьчлалын Сан ХОС	342,534	1.4	314,294	1.4	(284,922)
12 Бодь Даатгал ХК	212,594	0.9	203,994	0.9	-
13 А.Сүхдорж	203,994	0.8	166,000	0.8	-
14 Ч.Амарбаатар	166,000	0.7	95,366	0.7	(263,158)
15 Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК	----	0	-	5.1	-
16 Бусад	5,186,793	20.7	5,042,578	20.2	(144,215)
НИЙТ	25,000,000	100	25,000,000	100	-
Хувьцаа эзэмшигчдийн тоо	9,515		9,763		248

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Засаглалын бүтэц үйл ажиллагаа

Бид 1994 онд анхны хувийн даатгалын компани болон байгуулагдаж байсан бөгөөд 2018 онд олон нийтэд нээлттэйгээр хувьцаагаа санал болгон даатгалын салбарт анх IPO хийж Монголын Хөрөнгийн Биржийн 1-р ангиллын хувьцаанд багтан хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй нээлттэй хувьцаат компани болсон байна.

Ард Даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл нь ерөнхий удирдлагаар ханган ажилладаг. Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилон ажиллаж байна.



ХҮНИЙ НӨӨЦ



Ард Даатгал ХК нь 2023 оны байдлаар дунджаар 94 орчим ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явууллаа.

Компанийн хүний нөөцийн бодлогын хувьд ажилтнуудын сэтгэл ханамжтай байдлыг дэмжих, мөн алсын хараа эрхэм зорилгын төлөө хамтдаа хөгжих боломжийг байнга олгож байхыг эрмэлзэн ажилтнуудыг хөгжүүлэх сургалтуудыг тасралтгүй зохион байгуулж байна. Мөн уян хатан цагийн системийг нэвтрүүлэн үр ашигтай цагийн зохицуулалтыг бий болгохын зэрэгцээ ажилтан бүрийг эрүүл мэндийн даатгалд жил бүр хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулдаг. Ажиллах орчныг таатай байлгаснаар бүтээлч сэтгэлгээ, багаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд зорин ажиллаж байна. Ажилтнуудыг санхүүгийн хувьд хараат бус байх боломжийг байнга дэмжин ажиллаж хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг нэвтрүүлсэн бөгөөд компанидаа болон нэгдлийн оролцогч компаниудад хөрөнгө оруулагч болохыг дэмжин жил бүр урамшууллаар хувьцаа хуваарилж, сар бүр ажилтны тэтгэврийн хуримтлалын дансанд орлого хийж ирсэн.

Компанийн хувьд ажилтнуудын тогтвор суурьшилтай байдал хангалттай буюу 3 жилээс дээш ажиллаж байгаа ажилтны эзлэх хувь 50 хувьтай байна.

Судалгаанаас ажиллагсдын онцлон дурдсан сэтгэл ханамжтай байдлын үзүүлэлтийг харахад нийт ажиллагсдын 31% нь урамшуулалд, цагийн уян хатан байдалд 19%, 15% нь бүх зүйлд сэтгэл ханамжтай гэсэн бол 29% нь орчин нөхцөл гэсэн хариултыг сонгосон байна.

Сургалт

2023 онд төв болон орон нутгийн ажиллагсдад мэргэжлийн ур чадварын, хувь хүний хөгжлийн, байгууллагын үйл ажиллагаатай уялдаж зайлшгүй хамрагдах нийт 222 цагийн сургалт зохион байгуулагдсан байна.

Комплаенс

МУТСТ дотоод хяналтын хөтөлбөрийн дагуу Харилцагчийг таньж мэдэх асуулгыг харилцагчдаас авахыг тогтмолжуулахаар ажиллаж байна.

МУТСТ дотоод хяналтын хөтөлбөрийн тайланг жил бүр ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны хуралд танилцуулж ажиллаж байна.

Мэдээлэл технологи, цахимжилт

2023 онд Жолоочийн хариуцлагын даатгалыг онлайнаар хийдэг болгож Ард апп болон "АТҮТ"-н autobox апп, Үндэсний дата төвтэй хамтран жолоочийн хариуцлагын даатгалыг цахимаар цаг алдахгүй түргэн хийдэг боллоо.

Брокер болон зуучлагч компаниудтай хамтран системийн холболт хийж борлуулалтын сувгийг нэмэгдүүллээ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал

ТУЗ-ийн 2023 оны 3 сарын 14-ны өдрийн 02/23 тоот тогтоолоор 2023 оны 4 сарын 29-ний өдрийн 10:30 цагт Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахаар шийдвэр гарсан бөгөөд тус шийдвэрийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж, Нийслэлийн Соёлын Төв Өргөөний танхимд амжилттай зохион байж, доорх асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. 2021 оны цэвэр ашгаас хуваарилж олгосон ногдол ашгийн тайланг танилцуулах тухай;
3. 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;

Төлөөлөн удирдах зөвлөл

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.

2021 оны 4 сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд хоёр удаа эчнээгээр, таван удаа ээлжит хурал зохион байгуулсан бөгөөд хурлаар Ногдол ашиг олгох эсэх тухай, ХЭХ хуралдуулах тухай, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг томилох, компанийн төсөв, улирал, жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан болон бусад цаг үеийн асуудлуудыг хэлэлцэж шийдвэрүүд гаргаж ажилласан байна. Мөн Ард Даатгал ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороотой байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

Төлөөлөн удирдах зөвлөлийн Дарга



Одончимэдийн Одбаяр
ТУЗ-ийн гишүүн
Ард Санхүүгийн Нэгдэл

Ердийн гишүүд



Одончимэдийн Одбаяр
Гүйцэтгэх захирал
Ард Даатгал ХК



Галнямын Уянга
Гүйцэтгэх Захирал
Ард Пропертиз



Батбилэгийн Золбоо
Гүйцэтгэх захирал
Ард Санхүү Нэгдэл ХК



Чулуун Ганзориг
Гүйцэтгэх захирал
Ард Экс ХХК



Сүхдорж Оргил
Гүйцэтгэх захирал
Мост Финтек ХХК

Хараат бус гишүүд



Зоригт Ариун
Төслийн удирдагч
Занаду Резиденс



Баатарзоригт Болорчимэг
Үүсгэн байгуулагч
Өрөг.МН



Төмөр Билгээ
Уул уурхай хариуцсан захирал
Эрдэнэс Баянбогд ХХК

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийг эрт илрүүлэх, үнэлэх, удирдахын тулд дотоодын болон зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлүүдийг тооцоолж компанийн эрсдэлийн хороо болон төлөөлөн удирдах зөвлөлд тогтмол танилцуулах замаар хяналтын болон гүйцэтгэлийн тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна. Ингэснээр бидэнд эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, оновчтой удирдах, цаашлаад өөрийн давсан эрсдэлийг давхар даатгалд шилжүүлэн ажиллах боломжийг олгож байна.

Санхүүгийн үзүүлэлт (сая төгрөг)

	Хураамж	Нөхөн төлбөр	Давхар даатгал	Нийт хөрөнгө	Нөөц сан	Цэвэр ашиг
2023	32,438	14,095	5,660	44,156	22,367	3,277
2022	22,315	7,858	4,231	35,645	14,704	737
2021	16,462	4,967	2,399	34,826	11,708	7,176

Нийт хөрөнгө 44.2 тэрбум төгрөгт хүрсэн буюу өмнөх оноос 24.0 хувиар, хөрөнгө оруулалтын багц 28.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 19.6 хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн байна.

Нийт хураамжийн орлогын хувьд төлөвлөгөөгөө 29.8 хувиар давуулсан буюу өмнөх оноос 45.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Харин нийт олгосон нөхөн төлбөр өмнөх оноос 79.3 хувиар өссөн байна.

Даатгалын багцын мэдээлэл (сая төгрөг)

	Хураамж			Нөхөн төлбөр			Давхар даатгал			
	2022	2023	ХУВЬ	2022	2023	ХУВЬ	Хураамж		Нөхөн төлбөр	
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	4,395	5,217	16	1,760	2,197	16	423	7	196	5
Хөрөнгийн даатгал	4,212	5,557	17	121	1,103	8	3,761	66	729	19
Авто тээврийн хэрэгслийн даатгал	4,115	6,982	22	1,301	2,608	19	-	0	-	0
Ачааны даатгал	265	348	1	96	36	0	39	1	-	0
Барилга угсралтын даатгал	2,988	552	2	354	-	0	554	10	-	0
Хариуцлагын даатгал	1,540	2,064	6	76	80	1	507	9	-	0
Жолоочийн хариуцлагын даатгал	3,363	7,957	25	2,533	4,157	29	0	0	-	0
Бусад (8 хэлбэр)	1,437	3,762	12	1,617	3,914	28	376	7	2,879	76
Нийт	22,315	32,438		7,858	14,095		5,660		3,804	

Тайлант хугацаанд 32 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэн ажилласан байна. Энэ нь 2022 онтой харьцуулбал 9.2 тэрбум төгрөгөөр буюу 41 хувиар нэмэгдүүлэн ажиллалаа

Харьцаа үзүүлэлт

(Цэвэр хураамжаас тооцов. Харьцаа үзүүлэлт < 100%, **ТӨЛБӨРИЙН ЧАДВАР ХАНГАЛТТАЙ ТҮВШИНД**)

	Хохирлын харьцаа	Зардлын харьцаа	Хосолсон харьцаа
2023	41%	56%	97%
2022	40%	59%	99%
2021	36%	71%	107%

ДАВХАР ДААТГАЛ

Ард Даатгал компани 2003 оноос хойш Англи, Америк, Герман, Япон, Сингапур, Швейцар зэрэг олон улсын өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын томоохон компаниудад тогтмол даатгуулж ирсэн туршлагатай билээ. Бид ХБНГУ-ын Аллианц компанитай стратегийн түншлэлийн хүрээнд урт хугацааны туршид хамтран ажиллаж байна. Мөн Ханновер Ри, Монголиан Ри, Свисс Ри зэрэг компаниуд нь манай байнгын хамтран ажилладаг давхар даатгагч бөгөөд бид өөрсдийн эрсдэлийн багцыг факультатив болон трити гэрээ байгуулан давхар даатгуулдаг. Бид даатгалын үйлчилгээндээ давхар даатгалын хамгаалалт авахаас гадна тухайн даатгалын зүйл, гэрээний хувьд хамгийн сайн тохирох хамгаалалтыг сонгохыг хичээн ажилладаг юм.

Даатгалын багцын мэдээлэл (сая төгрөг)

	2022 он		2023 он	
	Хураамж	Хувь	Хураамж	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	481	11	423	7
Хөрөнгийн даатгал	1,749	41	3,761	66
Ачааны даатгал	35	1	-	0
Барилга угсралтын даатгал	1,589	38	39	1
Мал амьтдын даатгал	96	2	554	10
Хариуцлагын даатгал	162	4	507	9
Санхүүгийн	119	3	0	0
Нийт	4,230		5,660	





Хамтран ажилладаг давхар даатгагч, брокер



Давхар даатгалын төрлөөр авч үзвэл нийт давхар даатгалын хураамжийн 27 хувийг факультатив, 59 хувийг фронтинг, 14 хувийг трити эзэлж байна.

Ард Даатгал ХК-ийн давхар даатгуулсан эрсдэлийн 65 хувийг Европын зах зээл, 19 хувийг Азийн зах зээл, 12 хувийг Монгол улсын давхар даатгалын зах зээл, 4 хувийг Африкийн зах зээлд эрсдэлийг тараан байршуулж ажилласан байна.





2023 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

Ард Даатгал ХК-ийн Аудитлагдсан санхүүгийн тайлан



“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

**Хураангуй санхүүгийн тайлангийн
талаарх Хараат бус аудиторын
дүгнэлт**

Далай тэвэр 9 даяар, ЮНЕСКО
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

“Ард Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид “Ард Даатгал” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь аудитын тайлангийн тодруулгад тайлбарласны дагуу бүхий л материаллаг зүйлсийн хүрээнд аудит хийгдсэн тайлантай нийцэж байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Сангийн сайдын 2020 оны 132 тоот тушаалаар батлагдсан “Даатгалын компаниудад мөрдөгдөх Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга”-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул “Ард Даатгал” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.



Монгол улс, Улаанбаатар хот
1118276081 | 2577942
2024 оны 3 дугаар сарын 28

Ард Даатгал ХК-ийн Аудитлагдсан санхүүгийн тайлан

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,226,869	814,417
Даатгалын авлага	3,836,634	5,638,403
Бусад санхүүгийн хөрөнгө	1,052,075	752,084
Бусад санхүүгийн бус хөрөнгө	1,687,569	548,452
Хөрөнгө оруулалт	24,732,264	24,181,282
Даатгалын хөрөнгө	5,041,262	3,091,172
Үндсэн хөрөнгө (цэвэр)	666,244	405,608
Биет бус хөрөнгө (цэвэр)	2,913,296	213,093
Нийт хөрөнгө	44,156,213	35,644,511
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Даатгалын өглөг	1,910,825	2,220,430
Бусад санхүүгийн өр төлбөр	754,822	694,789
Бусад санхүүгийн бус өр төлбөр	905,817	1,345,534
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	17,815,647	11,569,702
Нөхөн төлбөрийн нөөц сан	4,551,184	3,134,774
Өр төлбөрийн нийт дүн	25,938,295	18,965,229
Эздийн өмч		
Энгийн хувьцаа	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал	3,280,854	3,280,854
Дахин үнэлгээний үнэ цэнийн бууралт	(1,985,923)	(267,492)
Хуримтлагдсан ашиг	11,922,987	8,665,920
Эздийн өмчийн дүн	18,217,918	16,679,282
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	44,156,213	35,644,511

Ард Даатгал ХК-ийн Аудитлагдсан санхүүгийн тайлан

Ард Даатгал ХК
Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулгууд
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн хувьд (өөрөөр тусгайлан заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлэв)

Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	2023 он	2022 он
Даатгалын үйл ажиллагаа		
Даатгалын хураамжийн нийт орлого	32,438,210	22,315,689
Даатгалын хураамжийн буцаалт	827,655	468,805
Давхар даатгалын хураамжийн зардал	5,660,407	4,230,922
Даатгалын хураамжийн цэвэр орлого	25,950,148	17,615,962
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(6,245,945)	(3,262,702)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	442,578	662,283
Орлогод тооцсон хураамж	20,146,781	15,015,543
Нийт нөхөн төлбөрийн зардал	14,095,483	7,858,896
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	3,803,653	254,590
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	1,950,932	1,574,204
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	8,340,898	6,030,102
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	311,455	(244,479)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	(74,721)	(10,437)
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	1,104,956	(22,097)
Зардалд тооцсон нөхөн төлбөр	9,682,588	5,753,089
Даатгалын гэрээний зардал	4,114,931	2,590,349
Давхар даатгалын шимтгэлийн орлого (зардал)	172,436	143,466
Хөрөнгө оруулалтын орлого ба олз (гарз)	3,144,879	435,828
Даатгалын үйл ажиллагааны ашиг	9,666,577	7,251,399
Хүү, эрхийн шимтгэлийн орлого	20,510	-
Бусад орлого	378,907	191,590
Ерөнхий ба удирдлагын зардал	2,044,144	2,355,406
Борлуулалт, маркетингийн зардал	4,577,808	3,796,194
Санхүүгийн зардал	24,163	13,785
Бусад зардал	440,589	202,222
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	76,845	(226,860)
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз	(543)	54,106
Бусад ашиг (алдагдал)	(6,610,985)	(6,348,771)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,055,592	902,628
Орлогын татварын зардал	(221,656)	165,973
Татварын дараах ашиг (алдагдал)	3,277,248	736,655
Бусад дэлгэрэнгүй орлого		
Дахин үнэлгээний үнэ цэнийн бууралт	(1,985,923)	(267,492)
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	1,291,325	469,163
Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	0.052	0.019



ХҮЧТЭЙ. ХАМТДАА.